



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БАГА БОЛОВСРОЛ



# МОНГОЛ ХЭЛ

БАГАНАН КОД  
НААХ ХЭСЭГ

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....



### Засалтын хүснэгт

Даалгаврын дугаар		Авсан оноо
I		
II		
III		
IV		
V		
VI		
VII	A	
	Б	
VIII		
IX		
X	A	
	Б	
	В	



### САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Цэвэр гаргацтай бичээрэй.
- Эхийг уншаад, даалгаврыг зааврын дагуу гүйцэтгээрэй.

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. УНШИХ

Тус уу, заль уу?

Цасан шуурга намдах шинж алга. Бид гол дээр ирж шуудайгаа мөсөөр дүүргэж, чарган дээр баглаад, салхи сөрөн алхахад нулимс гүйлгэнээд зам харагдахгүй болов. Илч нь гарсан ноосон малгайтай намайг салхи нүүр нүдгүй шавхуурдана. Харин үнэгэн лоовуузыг эрүүвчилж, хурган бээлий өмссөн Цэнд хөмсөг сормуус нь цантан, хацар нь гүйцэд боловсорсон алим адил улаа бутарч явлаа.

Эрүү минь дагжин чичирч, яг л осгодог дээрээ туллаа. Түр ч гэсэн нөмөрлөх санаатай Цэндийн араар орон хэд алхтал тэр гэнэт зогтосон “Чи яасан монжооч юм бэ? Дэмий шүү!” гэж хялайв. Тэр үед би Цэндийг өрөвдөх сэтгэлгүй аминчхан зант гэж амандаа бувтнаад, зэрэгцэн алхав. Хариугүй хөлдүүс болдгийн даваан дээр айлын хашааны нөмөрт ирж жаахан бүлээцэх шиг болов.

Гэнэт Цэнд миний чарган дээрх мөсийг өөрийнх дээрээ ачаад, лоовуузаа надад өмсүүлэв. Тэгээд “Дүүрэн минь түрүүлээд харьж бай! Нээрэн их даарчхаж. Хараач, наад хамар чинь бараг тасрах нь ээ! Найз нь чиний мөсийг аваад очъё” гэлээ. Миний баярласан гэж жигтэйхэн. Золтой л нулимс мэлмэрүүлчихсэнгүй. Би хоосон чаргаа чирсээр гүйж харив. Ээж намайг “Дүүрсэн хүн шүү, дулаалж явахгүй! Хүний хүүхдийн хувцас аваад, амьтны үрийг осгоох нь ээ” гээд хангинав. Удалгүй Цэнд аахилсаар хүрч ирэхэд нь би найзыгаа буруутгаж бодсондоо ичингүйрч суулаа.

**Үгийн утгын тайлбар:** Лоовууз – Үстэй малгай

1 Хүүхдүүд гол дээр яах гэж ирсэн бэ?

---



---

2 Эхийн гол хэсгийн санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж,  тэмдэглээрэй.

- Дүүрэнгийн маш их даарч байгаа тухай
- Цасан шуурга хүчтэй шуурч байсан тухай
- Цэндийн аминчхан зангийн тухай

3 Өгүүлбэрийг уншаад, Цэндийн хийсэн үйл хөдлөлөөс тохирохыг бичээрэй.

Дүүрэн маш их даарсан учраас

Цэнд

.....

4 Эхлэл хэсгээс “Гадаа маш хүйтэн байгааг” илэрхийлсэн хоёр жишээ олж бичээрэй.

---



---



5 Зохиолоос “Цэндийн хацар”- ыг дүрсэлсэн хэсгийг олж бичээд, тайлбарлаарай.

.....  
.....

6 Эхлэл хэсгээс Дүүрэнгийн даарах болсон шалтгааныг илэрхийлсэн өгүүлбэрийг олж бичээрэй.

.....  
.....

7 А. Цэндийн бодлын өөрчлөлтийг нөхөж бичээрэй.

	Гол хэсэгт	Төгсгөл хэсэгт
Дүүрэн	Аминчхан зант гэж бодсон.	Найзыгаа буруутгаж бодсондоо ичингүйрч суулаа.
Цэнд	..... ..... .....	..... ..... .....

Б. Баатруудын бодлын өөрчлөлтөөс ямар дүгнэлт хийж болох вэ?

.....  
.....  
.....

8 Дүүрэн гэртээ хоосон чаргаа чирж ирэхдээ ямар дүр төрхтэй байсныг төсөөлж бичээрэй.

.....  
.....

